



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 01/07

Жаргалтхаан сум

Шалгалтын комисс томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 4.2 дахь заалт, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвийн хамтран баталсан “Анги дэвших, улсын шалгалт зохион байгуулах удирдамж”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа суралцагчдын мэдлэг, чадвар эзэмшилтийг үнэлэх зорилгоор анги дэвших, сургууль төгсөх шалгалтыг зохион явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Д.Чинбат (Сургалтын менежер)

Комиссын нарийн бичиг: С.Мөнхсаруул (Нийгмийн ажилтан)

Гишүүд: С.Наранцэцэг (БАСХБ-ийн ахлагч)

О.Жимсээ (БУСХБ-ийн ахлагч)

Д.Саранцацрал (НУСХБ-ийн ахлагч)

А.Мөнхбат (математикийн багш)

Б.Гэрэлмаа (англи хэлний багш)

Ч.Болормаа (орос хэлний багш)

Б.Сумъяа (монгол хэл, уран зохиолын багш)

2. Анги дэвших, сургууль төгсөх шалгалтыг зохих журмын дагуу зохион явуулж, дүнг цахим системд шивэх, үр дүнг захирлын дэргэдэх зөвлөлд тайлагнаж ажиллахыг комиссын дарга (Д.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ТӨМӨРБААТАР

D/Tushaal-2024

232401013